*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2020 оны 100 тоот тушаалын*
*7 дугаар хавсралт*

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах | | | | | | | |
| ***1.1 Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг оновчтой төлөвлөж, аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг зохион байгуулах*** | | | | | | | |
| 1.1.1 | Халдварт, зооноз өвчинтэй тэмцэх арга хэмжээг хууль, журам, зааврын дагуу зохион байгуулах, үр дүнг тайлагнах | УТ-135,0 сая ОНТ-106,5 сая Иргэн, ААН-16,5 сая Нийт 258 сая төгрөг | Халдварт өвчний гаралт буурсан байна. | Халдварт өвчний гаралт 40 хувиар буурсан. | Эхний хагас жилд: Мал, амьтны өвчнийг тандах 2025 оны төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах Жилийн эцэст: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайланг МЭЕГ, УМЭАЦТЛ-д хүргүүлэх | Мал, амьтны халдварт 11 өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 290.4 толгой малыг хамруулахаар төлөвлөн, аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/160 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/17 дугаар тушаалыг тус тус төлөвлөн батлуулсан. Арга хэмжээний хэрэгжилт 32.6 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. | 100 |
| 1.1.2 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан малын тоо | Гоц халдварт өвчнөөс сэргийлэх 2 тарилгад 264.4 мянган толгой мал хамруулсан. | Эхний хагас жилд: 40,0 мянган толгой мал, амьтан Жилийн эцэст: 60,0 мянган толгой мал, амьтан | Аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/202 дугаар "Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт зохион байгуулах тухай" захирамж, Газрын даргын 2025 оны А/21 дугаар тушаал, удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 59.6 мянган толгой үхрийг хамруулахаар төлөвлөсний дагуу Мал эмнэлгийн нэгдсэн системд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөлтийг бүрэн оруулж, 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс дархлаажуулалтын ажлыг эхлүүлсэн. Тайлант хугацаанд 59,6 мян/тол үхрийг хамруулахаар төлөвлөн 55,4 мянган толгой үхрийг хамруулж 92,9 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. | |
| 1.1.3 | Мал, амьтны өвчнийг тандах, эрт илрүүлгийн арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих, баталгаажуулах, үр дүнг үнэлэх | Үйл ажиллагааны зардлаар | Тандалтын арга хэмжээний гүйцэтгэл | Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/54 дугаар "Мал эмнэлгийн идэвхгүй тандалтын төлөвлөгөө батлах тухай", А/134 дугаар "Тандалтын төлөвлөгөө батлах тухай" тушаалын дагуу гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн арга хэмжээнд 164 өрхийн 11.8 мян/тол мал, шулхий өвчний | Эхний хагас жилд: Мал, амьтны өвчнийг тандах 2025 оны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах Жилийн эцэст: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайланг МЭЕГ, УМЭАЦТЛ-д хүргүүлэх | Монгол улсад "Ямааны годрон" өвчин дахин бүртгэгдсэнтэй холбоотой ямааны годрон өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Дархан-Уул аймгийн хэмжээнд шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг Google form цахим сүлжээгээр сумдаас сар бүр авч нэгтгэн 6 Идэвхгүй тандалтын дүнг хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн нутагт ямааны годронгийн шинж тэмдэг үзүүлсэн болон сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.Мөн шулхий өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг Google form цахим сүлжээгээр хийж нийт 36 өрхийг хамруулан асуумж судалгааг авч дүн шинжилгээ хийхэд сэжигтэй тохиолдол илрээгүй. Хонгор сумын Цагаан нуур орчимд адууны томуугийн шинж тэмдэг үзүүлсэн гэсэн дуудлагын дагуу 10 адууны цусны дээж, ийлдсийн дээж, арчдас, хамрын гоождос авч Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид илгээж шинжлүүлэхэд 25-2571 дүнгийн хуудсаар адууны томуугийн эсрэгбием илэрсэн тул 26 өрхийн 1145 толгой адууг хамруулахаар төлөвлөж албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичиг илгээсэн. Мөн адууны томуугийн өвчний тархалтын байдалд хяналт тавих зорилгоор сумдын адуутай айл өрхүүдээс шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг 8 малчин өрхөд хийхэд адууны томуугийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй. Мал эмнэлгийн нэгдсэн системд эрт илрүүлгийн үзлэг тандалтыг 208 өрхийн 20.0 мян/тол малд хийж бүртгэсэн бөгөөд сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна. | |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах | | | | | | | |
| ***2.1.Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх*** | | | | | | | |
| 2.1.1 | Мал эмнэлгийн тасаг, нэгжийн үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжийн хүрээнд дотоод хяналт, шалгалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт шалгалтын тоо Зөвлөмжийн биелэлтийн хувь | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/94 дүгээр тушаалын 46 дугаар хавсралтаар батлагдсан 8.44.1 кодтой Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг шалгах хяналтын хуудсаар дүгнэсэн. Дархан-Уул аймгийн 4 мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагааг 28 үзүүлэлтээр шалгахад Дархан сум 81.2, Хонгор сум 58.2, Орхон сум 85.3, Шарын гол сум 56.3 хувьтай үнэлэгдсэн. | Эхний хагас жилд: Хяналт шалгалтын тоо Зөвлөмжийн биелэлтийн хувь Жилийн эцэст: Хяналт шалгалтын тоо Зөвлөмжийн биелэлтийн хувь | Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/83 дугаар тушаалын дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2-4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд хяналт шалгалт зохион байгуулах тухай удирдамжийн дагуу Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй 10 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд түүврийн аргаар урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн байдал, холбогдох заавар журмын хэрэгжилт, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тарилгын акт, мал эмнэлгийн нэгдсэн системийн хөтөлсөн байдалд газар дээрх явцын гүйцэтгэлд хяналт шалгалтыг 15 удаа хийж, илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой улсын байцаагчийн 7 заалт бүхий 1 зөвлөмжийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хүргэсэн. Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг нийт 7 удаагийн давтамжтайгаар хүргэсэн. | |
| 2.1.2 | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандарт, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт хийх, санхүүжилт олгох. | Үйл ажиллагааны зардлаар | Стандартын хэрэгжилт | 85 | Эхний хагас жилд: 2 аан, 58 хувь, санхүүжилтыг тухай бүр олгосон байна. Жилийн эцэст: 3 аан 65 хувь, санхүүжилтыг тухай бүр олгосон байна. | Салбарын хяналтын газрын 08-00-03/13 удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад Сэлэнгэ гранд арго ХХК-г хамруулахаар сонгогдсон бөгөөд 06 дугаар сард хяналт шалгалтыг хийхээр бэлтгэл ажлыг хангасан.Орон нутгийн төсвөөс санхүүжих дархлаажуулалтын урьдчилгаа болох 22,1 сая төгрөгийг тайлант хугацаанд олгосон | 90 |
| 2.1.3 | "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах " чиглэлээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ байгуулах, үр дүнг тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Гэрээний биелэлт | Мал эмнэлгийн үйлчилгээний 10 нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний биелэлт дунджаар 85 хувь. | Эхний хагас жилд: гэрээ байгуулах, Жилийн эцэст: Гэрээний биелэлт 88 хувь. | Мал эмнэлгийн газар, сумдын Засаг даргын тамгын газар, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд 2025 онд хамтран ажиллах гэрээг мал эмнэлгийн үйлчилгээний 10 нэгжтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан. Тус гэрээний дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд эм биобэлдмэлийг олгож, гүйцэтгэлд хяналт тавьж хагас жилийн байдлаар гэрээний биелэлтийг дүгнэсэн. | 100 |
| Төрийн захиргаа | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***2.2 Авлига, ашиг сонирлоос ангид, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахин иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх*** | | | | | | |
| 2.2.1 | Аймаг хооронд болон аймаг доторх мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ, хүнсний зах, худалдааны төвүүдэд худалдааны төвүүдэд худалдан борлуулж байгаа бүтээгдэхүүнд мал эмнэлгийн, магадлан шинжилгээний гэрчилгээ олгох, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, үйлчилгээг өргөтгөх | Үйл ажиллагааны зардал | Олгосон гэрчилгээний тоо Хяналт шалгалтын тоо | Хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж буй мах, махан бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх 5 удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант хугацаанд хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж буй мах, махан бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд 94 обьект, 211 иргэнийг хамруулж 254 зөрчлийг илрүүлж 114 буюу 44,8 хувийг газар дээр нь арилгуулж 1 иргэнд зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцсон. | Эхний хагас жилд: Олгосон гэрчилгээний тоо -1000 Хяналт шалгалтын тоо Жилийн эцэст: Олгосон гэрчилгээний тоо -3000 Хяналт шалгалтын тоо | Мал эмнэлгийн газрын улсын байцаагч болон сумдын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг зөрчсөн 4 иргэнд шийтгэврийн арга хэмжээ авч, 550.0 мянган төгрөгийн торгуулийг ногдуулж 100 хувь төвлөрүүлэн материалыг аймгийн прокурорын газарт хүргүүлэн хянуулсан. Тайлант хугацаанд 27 мал эмнэлгийн гэрчилгээтэй 74 толгой мал амьтан отор, нүүдэл, үржлийн зориулалтаар аймгийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн гэрчилгээтэй шилжин ирсэн. Нийт шилжилт хөдөлгөөний 54 хувийг адууны шилжилт хөдөлгөөн эзэлж байна. Мах, махан бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт тавих тухай 9 удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад давхардсан тоогоор 15 обьект, 4 аан, 85 иргэн хамрагдаж хяналт шалгалтын явцад 125 зөрчил дутагдлыг илрүүлж 95 зөрчил буюу 76 хувийг газар дээр нь арилгуулж, мах, махан бүтээгдэхүүн, арчдасны 225 дээжийг Мал эмнэлгийн лабораторид хүргүүлэн ажилласан бөгөөд стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн илрээгүй. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2 | Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх, экспортлох иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ баталгаажуулалтыг хийж, лабораторийн шинжилгээний дүнг хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Бүтээгдэхүүний тоо | Мах, махан бүтээгдэхүүний 817, дайвар бүтээгдэхүүний 63, сүүн, сүүн бүтээгдэхүүний 453, зөгийн балын 11, өндөгний 28 нийт 1372 дээжид шинжилгээг итгэмжлэлийн хүрээнд хийж хариуг vetlab.shinligee.mn цахим системд оруулж баталгаажуулан шинжилгээний дүнг холбогдох иргэн, аж ахуй нэгжид шуурхай хүргэсэн.Ноос, ноолуур боловсруулах 2 үйлдвэрийн БНХАУ, Энэтхэг, Испани улсуудад экспортлох үхэр, сарлаг, хонины хагас боловсруулсан хөх шир 19115 ширхэг бүтээгдэхүүний 20 дээжид шинжилгээ хийсэн. | Эхний хагас жилд: 10.000<br>Жилийн эцэст: 10.000 | Мал эмнэлгийн лабораториийн ариун цэвэр магадлан шинжилгээний лабораторид мах, махан бүтээгдэхүүний 1037 сорьцын 5185 шинжилгээ, сүү, сүүн бүтээгдэхүүний 710 сорьцын 2840, өндөгний 71 сорьцод 284 шинжилгээ, зөгийн балны 22ш сорьцын 44 шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж үр дүнг баталгаажуулсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүнсний аюулгүй байдлын баталгаажилтад хамруулсан сорьцын тоо 3 дахин нэмэгдсэн байна. Дархан меат фүүдс ХХК нь 2025 оны хагас жилийн байдлаар Бүгд Найрамдах Хятад ард улс руу чанасан ямааны мах-900 тн, үхрийн чанасан мах 325 тн, Узбекистан улс руу хонины ястай мах-40 тн, адууны гол мах-40тн, адууны шулсан мах-10тн, хонины мах-60 тн, Исламын бүгд найрамдах улс руу-50 тн хонины мах, Казакстан улс руу 17 тн хонины махыг нийт 4 улс руу 1442 тн махыг 12 удаагийн тээвэрлэлтээр экспортолсон байна. | 100 |
| 2.2.3 | Малын эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, Vetdrug.mn-д бүртгэх, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт шалгалтын тоо, системд бүртгэсэн нэгж | 2 эмийн сан | Эхний хагас жилд: 1 эмийн сан<br>Жилийн эцэст: 1 эмийн сан | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 08-00-03/13 удирдамжийн дагуу малын эмийн худалдаа эрхлэдэг "Дэлгэрэхноён трейд" ХХК-г хяналтын хуудсаар үнэлэхэд 15.8 хувь буюу бага эрсдэлтэй, хууль тогтоомжийн биелэлт 84.2 хувиар, "Үржилт мал" ББН-г хяналтын хуудсаар үнэлэхэд нь 34.6 хувь буюу дунд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрсдэлтэй, хууль тогтоомжийн биелэлт 65.4 хувиар тус тус үнэлэгдэж улсын байцаагчийн 15 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг 2 малын эмийн сангаар нийт 1215 л боловсруулалтын бэлдмэл, 1550 л Албендазол туулга, 825 л угаалгын бодис худалдан борлуулсан байна.Мөн малчид иргэдийн худалдан авсан эм бэлдмэлийн 60 гаруй хувь нь антибиотик, 30 гаруй хувь нь шимэгчтэх өвчний эсрэг эм бэлдмэл ээлж байна. | |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах | | | | | | | |
| ***3.1.Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулах*** | | | | | | | |
| 3.1.1 | Мал, амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эмчлэн сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Хамрагдсан малын тоо/өвчний бууралт | Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн Засаг даргын нэг захирамж, сумдын ИТХ-аас баталсан 4 тогтоолын хүрээнд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээнд 457.2 мян/тол мал, амьтныг хамруулж гүйцэтгэл 85 хувьтай хэрэгжиж дууссан. Өвчний гаралт тархалт | Эхний хагас жилд: 35,1 толгой мал амьтан<br>Жилийн эцэст: 155,1 толгой мал амьтан | Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх тухай мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/39 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 01-А/160 дугаар захирамжийн хүрээнд угаалга, туулгалт, боловсруулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 477.1 мян/тол мал, амьтныг хамруулахаар төлөвлөн өссөн дүнгээр нийт 151.4 мян.толгой малыг хамруулж гүйцэтгэл хагас жилийн байдлаар 95.7 хувьтай байна. Бүртгэгдсэн шимэгчтэх өвчний тохиолдол нь 2024 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өмнөх оны мөн үеэс 60 хувиар буурсан дүнтэй. | | мөн үетэй харьцуулахад 18.2%-иар буурсан. | |
| 3.1.2 | Халдваргүй өвчнөөс эмчлэн, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, үр дүнг тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Мал эмнэлгийн дуудлага мэдээлэл Судалгаа, санал Хамтран хэрэгжүүлэсэн төсөл, хөтөлбөрийн тоо | Мал сүргийн эрүүл мэндийн үзлэгийг гоц халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчний дуудлага, эрт илүүлэг болон үзлэг зөвлөгөө хийх арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 831.7 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 95 хувьтай | Эхний хагас жилд: Мал эмнэлгийн дуудлага мэдээлэл - 100 Судалгаа, санал-1 Хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо-1 Жилийн эцэст: Мал эмнэлгийн дуудлага мэдээлэл -100 Судалгаа, санал- 1 Хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо-1 | Мал эмнэлгийн нэгдсэн системд халдваргүй өвчний 315 дуудлагын дагуу мал, эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Аймгийн хэмжээнд халдваргүй өвчний гаралтыг авч үзвэл 21 төрлийн халдваргүй өвчнөөр 336 толгой мал өвчилж мал эмнэлгийн тусламж авсан бөгөөд 9 мал хорогдсон. Системд бүртгэгдсэн нийт дуудлагын 62.5 хувийг эх барихын хүндрэл эзэлж байна. Мал сүргийн эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөний арга хэмжээний хүрээнд нийт 211.4 мянган толгой малыг хамруулахаар төлөвлөн, гүйцэтгэл 23.2 хувьтай арга хэмжээ үргэлжилж байна. Мал сүргийг халдваргүй өвчний аливаа эрсдлээс сэргийлэх зорилгоор "ОРХОН-2025" төслийг санаачлан Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай хамтран хэрэгжүүлэхээр хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Тандалт судалгаанд суурилсан дүгнэлтийг үндэслэн эндемик өвчнийг эмчлэн сэргийлэх зөвлөмж боловсруулагдан үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж бүрдэнэ. | 100 |
| 3.1.3 | Халдваргүйтгэлийн бодис, техник, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг | Үйл ажиллагааны зардлаар | Халдваргүйтгэлд хамруулсан объектын тоо Талбайн хэмжээ м.кв Арга хэмжээний тоо | Халдварт өвчин гарах болзошгүй эрсдлээс хамгаалах халдваргүйтгэлийн арга хэмжээнд нийт 529 объектын 357,8 мян/мкв талбайг хамруулж 2.2 тн | Эхний хагас жилд: Халдваргүйтгэл- 500 объект, 100,0 мянган метр квадрат Жилийн эцэст: Халдваргүйтгэл -1500 объект, 300,0 мянган | Аймгийн хэмжээнд зүй бусаар хорогдсон 829 толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулан устгаж, устгалын цэгийн 35.3 мян/м.кв талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийж арга хэмжээг 100 хувьтайгаар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, үр дүнг тайлагнах | | | халдваргүйтгэлийн бодис зарцуулсан байна. Арга хэмжээг хэрэгжүүлснээр мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж нийтийн эрүүл мэндийг болзошгүй эрсдлээс хамгаалсан. | метр квадрат | хэрэгжүүлж дууссан. Хашаа хороо халдваргүйтгэлийн 28.5 мян/мкв, нийтийн эзэмшлийн зам талбайн 2.2 мян/м.кв буюу нийт 30.7 мян/м.кв талбайд төлөвлөгөөт халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. | |
| 3.1.4 | Тархвар зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх, зураглалыг шинэчлэх, шийдвэр гаргалтад ашиглах | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээл судалгааны гүйцэтгэл, зураглал Тандалтын тоо | 2024 оны жилийн эцсийн мэдээгээр: Мал амьтны халдварт 2 төрлийн / дотрын халдварт хордлого, дуут хавдар/ өвчнөөр 19 толгой мал өвчилж, уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу арга хэмжээг хэрэгжүүлж нэмж өвчилсөн мал байхгүй байна. 2024 оны 12-р сарын 02-ны өдрийн байдлаар мал амьтны гоц халдварт өвчин гараагүй, халдварт өвчний гаралт өмнөх оноос 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шимэгчтэх өвчнөөр 291 толгой мал өвчилж, 20 толгой мал нь хорогдсон 271 толгой нь эдгэрсэн дүн мэдээтэй байна. | Эхний хагас жилд: Зураглал гаргах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал боловсруулах<br>Жилийн эцэст: Зураглал гаргах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал боловсруулах | Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн лабораторийн дүнгээр баталгаажсан 6 голомтын газар зүйн зураглалыг гарган, 2026 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтөд тусгахаар санал боловсруулан мал эмнэлгийн Ерөнхий газарт хүргүүлсэн. | 100 |
| 3.1.5 | МАЭМТХ, ЗГ-ын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлэх ЗГ-ын 2018 оны 266 дугаар тогтоолын хэрэгжилтийг | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт шалгалтын тоо, илрүүлсэн зөрчил Мал эмнэлгийн гэрчилгээний тоо | Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/64 дүгээр тушаалын дагуу газар дээрх хяналт шалгалтад 25 иргэнийг хамруулж мал эмнэлгийн гэрчилгээгүй мал тээвэрлэж, тууварлан ирсэн 7 иргэнд 1.100.0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулсан.Нийт шилжилт | Эхний хагас жилд: Хяналт шалгалт -2 Гэрчилгээ олголтод хяналт тавих<br>Жилийн эцэст: Хяналт шалгалт-2 Шилжилт хөдөлгөөний тайланг гаргаж танилцуулах | Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд засгийн газрын 2019 оны 43 тоот тогтоолын дагуу хяналт шалгалтыг зохион байгуулсан. Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг зөрчсөн 3 иргэнд шийтгэврийн арга хэмжээ авч, 400.0 мянган төгрөгийн торгуулийг ногдуулж 100 хувь төвлөрүүлэн ажилласан. Нийт шилжилт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангуулан хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах | | | хөдөлгөөний 69 хувийг Булган, Сэлэнгэ, Улаанбаатар хотоос ирсэн мал, амьтан эзэлж байна. Нийт шилжилт хөдөлгөөний 64 хувийг бог малын шилжилт хөдөлгөөн эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58,3 хувиар зөрчил буурсан байна. | | хөдөлгөөний 54 хувийг адууны шилжилт хөдөлгөөн эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар зөрчил буурсан байна. | |
| 3.1.6 | Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх вакцин, биобэлдмэлийг технологийн болон төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийлүүлэгдэж буй эсэх, чанар аюулгүй байдлын баталгаажуулалт, хүлээн авалт, хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ, зарцуулалтад хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | Нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээгээр заасан хугацаа, хэмжээ | Вакцин, биобэлдмэлийн зарцуулалт, хамгаалалттай холбоотой зөрчил бүртгэгдээгүй. Улсын төсвийн санхүүжилт 111215,1 төг, Орон нутгийн төсвийн санхүүжилт 88997,7 төг нийт 200212,8 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний хөлсөнд олгож төсвийн өргүй ажиллалаа.Дотоод хяналтыг сайжруулах зорилгоор тэмдэглэгээ хийх, хяналт тавих төлөвлөгөөт бус удирдамжийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээний 10 нэгжийн хавар, намрын дархлаажуулалтын 999 цодонд Qr код наан олгосон. | Эхний хагас жилд: Татан авалт, хадгалалт, түгээлт, хэрэглээнд хяналт шалгалт хийх Жилийн эцэст: Татан авалт, хадгалалт, түгээлт, хэрэглээнд хяналт шалгалт хийх, гэрээг дүгнэх | Хагас жилийн байдлаар Биокомбинат ТӨХХК-с 3 удаа, Мал эмнэлгийн Ерөнхий газраас гоц халдварт үхрийн арьс товруутах өвчний вакцины татан авалт нийт 4 удаагийн татан авалтад газар дээрх хяналт шалгалтыг хийсэн. Нийт 16 цувралын 649,6 литр идэвхгүйжүүлсэн вакцин, 18,1 мян/тун хуурай вакцин, 142,7 литр шингэлэгч, гоц халдварт өвчнөөс сэргийлэх 59.6 мянган тун, 119,2 литр шингэлэгчийг хүлээн авсан. Хүлээн авах үеийн температур-7,4, 7,6 градус байсан нь хүйтэн хэлхээний горимыг зөрчөөгүй байна. | 100 |
| Мал эмнэлгийн хяналт | | | | | | | |
| ***3.2.Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, хяналт тавих, мал эмнэлгийн нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, сурталчлах, хяналт тавих*** | | | | | | | |
| 3.2.1 | Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн хувь | Шалгалтаар 38 зөрчлийг илрүүлж 8 буюу 64 хувийг газар дээр нь арилгуулж 8 | Эхний хагас жилд: 30% Жилийн эцэст: 85%- | Хяналт шалгалтын 11 удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор 15 обьект, 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | буй объектуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | | | албан шаардлагыг хүргүүлж зөрчлийг 100 хувь арилгуулсан. | иас доошгүй | аан, 85 иргэн хамрагдаж хяналт шалгалтын явцад 125 зөрчил дутагдлыг илрүүлж 95 буюу 76 хувийг газар дээр нь арилгуулж, мах, махан бүтээгдэхүүн, арчдасны 225 дээжийг Мал эмнэлгийн лабораторид хүргүүлэн ажилласан бөгөөд стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн илрээгүй | |
| 3.2.2 | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт шалгалтын тоо | 25 удаагийн хяналт, баталгаажилт 100 хувь | Эхний хагас жилд: 5 удаагийн хяналт, баталгаажилт 100 хувь<br>Жилийн эцэст: 15 удаагийн хяналт, баталгаажилт 100 хувь | Дархлаажуулалтын технологи, явцын гүйцэтгэлд хяналт шалгалтыг 15 удаа хийж, илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой улсын байцаагчийн 7 заалт бүхий 1 зөвлөмжийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хүргэсэн. Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг нийт 7 удаагийн давтамжтайгаар хүргэж ажилласан. Мал, амьтны тухай хууль болон холбогдох заавар журмыг баримтлан ажиллах талаар 11 малын эмчид зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласанаар бүртгэгдсэн зөрчилгүй байна. | 100 |
| Мал эмнэлгийн лаборатори | | | | | | | |
| ***3.3. Нийтийн эрүүл мэнд, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах*** | | | | | | | |
| 3.3.1. | Нэг эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож хамтран ажиллах, малын эмч мэргэжилтнүүдийг зооноз өвчний шинжилгээнд | Үйл ажиллагааны зардлаар | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйл | Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд Аймгийн Засаг даргын 01-А/238 дугаар захирамжийн дагуу тандалт шинжилгээг хийж Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний дүнгээр | Эхний хагас жилд: Мэдээллийн тоо- 2 Шинжилгээнд хамруулсан мэргэжилтний тоо- 5<br>Жилийн эцэст: Мэдээллийн тоо- 2 Шинжилгээнд хамруулсан мэргэжилтний тоо- 15 | Зооноз халдварт фасциолёз хорхойг илрүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сараас эхлэн зах, худалдааны төвүүдэд худалдан борлуулж буй 7 бог малын элэг, 2 үхрийн элгэнд задлан шинжилгээ хийхэд фасциолёз хорхой илрээгүй. Малын шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх, малаас авах эдийн засгийн үр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах | | | зэрэг дүн үзүүлсэн өрхийн мэдээллийг аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.Дархан-Уул аймагт анх удаа зооноз Faciola hepatica төрлийн элэг цөсний сувагт шимэгчилдэг хорхойг лабораторийн шинжилгээгээр илрүлсэн нь Улсын хэмжээнд 4 дэхь удаагийн тохиолдол болсон. | | өгөөжийг дээшлүүлэх мөн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 онд Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ХОНГОР-2025 төслийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 15 сая төгрөг шийдвэрлүүлэн тандалт судалгааны ажлыг эхлүүлсэн. | |
| 3.3.2 | Малчид болон иргэдэд бичил биетний эсрэг эмийн хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээний тоо Хамрагдсан иргэний тоо | Малын эмийн сангуудад нэг удаа, иргэд малчдын хэрэглэж буй эм биобэлдмэлд өрхийн түвшинд нэг удаа нийт 2 удаагийн хяналт хийж малын эм, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх талаарх мэдээ, мэдээллийг 9 удаагийн давтамжтай нийт 563 малчин, мал бүхий өрхийн түвшинд хүргэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгснөөр мэдлэг мэдээлэл нь дээшилсэн. | Эхний хагас жилд: Арга хэмжээний тоо 1 Хамрагдсан иргэний тоо 150 Жилийн эцэст: Арга хэмжээний тоо 1 Хамрагдсан иргэний тоо 250 | Сумдад зохион байгуулагдсан малчдын зөвлөгөөнд оролцон 150 гаруй малчин болон мал бүхий иргэд оролцсон. Цахим хаягаар дамжуулан иргэдэд бичил биетний эсрэг эмийн хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. | 100 |
| 3.3.3 | Малын эмийн үлдэгдэл, бичил биетний тэсвэржилтийн тандалт зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Дээжийн тоо Дүгнэлт, зөвлөмж | Шалгалтаар нийт 45 зөрчил дутагдал илрүүлснээс 15 буюу 33 %-ийг шалгалтын явцад арилгуулсан. Шалгалтаар байгууллагын 11 обьектын хоол үйлдвэрлэлд хэрэглэхээр бэлтгэсэн 541.5 кг мах, 25 л сүү нь мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээнд хамрагдсан тухай гэрчилгээгүй байсан | Эхний хагас жилд: Дээжийн тоо -50 Дүгнэлт, зөвлөмж- 1 Жилийн эцэст: Дээжийн тоо -50 Дүгнэлт, зөвлөмж- 1 | Малын эмийн үлдэгдэл, бичил биетний тэсвэржилтийн тандалтын хүрээнд "Митсесор BST" багажаар маханд Бета-лактам, сульфонамид, тетрациклиний бүлгийн антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг хагас жилийн байдлаар мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний 81 дээжид 3 төрлийн антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг хийсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тул бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг тодорхойлох зорилгоор нийт 45 дээжийг шинжилгээнд хамруулсан. | | бөгөөд стандартын шаардлагад нийцсэн байна. | |
| 3.3.4 | Саалийн үнээний бруцеллёз өвчний тандалт шинжилгээ зохион байгуулах. | Үйл ажиллагааны зардлаар | Дээжийн тоо | 10254 дээж | Эхний хагас жилд: 1250 дээж Жилийн эцэст: 1250 дээж | Мал эмнэлгийн лабораторид сүүний 710, ийлдэс судлалын 346 буюу нийт 1056 сорьцод зооноз халдварт өвчний шинжилгээг хийж үр дүнг баталгаажуулсан. | |
| 3.3.5 | Мал, амьтны гоц халдварт өвчний тандалт шинжилгээ зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Дээжийн тоо | 2154 | Эхний хагас жилд: 500<br>Жилийн эцэст: 1500 | Гоц халдварт 2 өвчний идэвхгүй тандалтад 130 өрхийг хамруулсан.Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/173 тушаалын дагуу 2985 толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөгдсөн. Тус тушаалаар батлагдсан графикт хугацааны дагуу тандалт, шинжилгээний ажлыг 06 дугаар сараас эхлүүлэхээр төлөвлөгдсөн. | 90 |
| **3.4. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний шинжилгээг стандартын дагуу шинжлэх, дээж хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 3.4.1 | Халдварт, гоц халдварт өвчний вакцины дараах мониторинг зохион байгуулах. | Үйл ажиллагааны зардлаар | Дархлааны идэвх | 80 | Эхний хагас жилд: 80<br>Жилийн эцэст: 80 | Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирлын 2024 оны А/08 тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакцин мониторинг хийх тандалтын ажлын удирдамж”-ийн дагуу Дархан-Уул аймгийн Орхон, Шарын гол сумдын мал сүргээс сорьц цуглуулах ажилд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 12 өрхийн 72 толгой бог малаас цусны дээж авсан. Шарын гол сумаас 6 , Орхон сумаас 6 нийт 12 өрх тус бүрээс 3 хурга, 3 ишигнээс цусны дээж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авсан. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хариугаар дархлааны идэвх 85 хувьтай гарсан. | |
| 3.4.2 | Онош тодорхойлох зорилгоор орон нутгаас ирсэн эмгэгт дээжүүдийг хүлээн авч бүртгэлжүүлэн стандарт зааврын дагуу шуурхай шинжлэн, хариуг эздэд хүргүүлэх, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Дээжийн тоо, онош баталгаажуулалт | 43 дээж | Эхний хагас жилд: Онош баталгаажуулалт-95 хувь<br>Жилийн эцэст: Онош баталгаажуулалт-91 хувь | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс ирүүлсэн эмгэгт материалын дээжүүдийг хүлээн авч бүртгэлжүүлэн стандарт зааврын дагуу шуурхай шинжлэн, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дотрын халдварт хордлогын нийт 12 дээжид стандарт зааврын дагуу шинжилгээнд хамруулахад бүх дээжид зэрэг дүн үзүүлсэн.Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторид хэвшил тодорхойлох шинжилгээнд дээж хүргүүлсэн бөгөөд 25-2482 дүнгийн хуудсаар дотрын халдварт хордлого өвчний А хэвшил илэрсэн.Эхний хагас жилд нийт 19 өрхийн 83 дээжид нян судлалын шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсэн. Улсын Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид онош баталгаажуулах зорилгоор 8 дээжийг илгээсэн бөгөөд онош баталгаажилт 100 хувь. | 100 |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Төрийн захиргаа** | | | | | | | |
| **4.1 Төрийн захиргааны удирдлагын нэгдмэл байдлыг хангах** | | | | | | | |
| 4.1.1 | Дээд байгууллагын тогтоол шийдвэр, үүрэг даалгаварын хэрэгжилт, тайлагналтыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагааны зардлаар | Тогтоол шийдвэрийн хэрэгжилт Мэдүүлгийн тоо Өргөдөл гомдлын шийдвэрлэлт | 2023 оны ХАСХОМ-ийг 8 албан тушаалтан хугацаандаа мэдүүлсэн бөгөөд мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй болно. Шинээр томилогдсон 4 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон ХАСХОМ-ийг хуульд заагдсан хугацаанд гаргуулан баталгаажуулсан. Нийт 37 өргөдлийг журмын дагуу хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлүүлэн, өргөдөл гомдлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн | Эхний хагас жилд: Хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах Жилийн эцэст: Хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах | Тайлант хугацаанд 6 өргөдөл хүлээн авч, 6 өргөдөл шийдвэрлэж ажилласан.2025 оны өргөдөл гомдлын улирлын болон эхний хагас жилийн тайланг хугацаанд нь аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.Авлигын эсрэг хуулийн дагуу 10 алба хаагч ХАСХОМ, шинээр томилогдсон 1 алба хаагч ХАСУМ гаргасан. | 100 |
| 4.1.2 | Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт хийх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Тогтоол шийдвэрийн хэрэгжилт Мэдүүлгийн тоо Өргөдөл гомдлын шийдвэрлэлт | Хяналт шалгалт-2, шилэн дансны хөтлөлт-100% | Эхний хагас жилд: Хяналт шалгалтын тоо-1 Шилэн дансны хөтлөлтийн хувь-100% Жилийн эцэст: Хяналт шалгалтын тоо-1 Шилэн дансны хөтлөлтийн хувь-100% | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор тогтмол гарган баталгаажуулж, байгууллагын төсөв, төлбөр тооцоо, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, санхүүгийн бусад гүйлгээтэй холбоотой 88 мэдээллийг www.shilendans.gov.mn вэбсайтад өссөн дүнгээр байршуулсан. | 100 |
| 4.1.3 | Хүний нөөцийн цахим тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэн баяжуулах, судалгаа гаргах, газрын дарга болон чиглэл | Үйл ажиллагааны зардлаар | Бүртгэлийг тогтоосон хугацаанд шинэчлэн зохион байгуулж мэдээлсэн байх | Төрийн албан хаагчид холбогдох мэдээллийг бүрэн тусгасан, цахим мэдээллийн санг бүрдүүлсэн. | Эхний хагас жилд: Чанартай бүхий талыг хамруулан гүйцэтгэсэн, төрийн албан хаагчид холбогдох мэдээллийг бүрэн | Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлага, менежмент" цахим системд албан хаагчдын томилгоотой холбоотой 3 мэдээлэл, газрын үйл ажиллагаа, бүтэц орон тоо, зохион байгуулалт, цалин хөлстэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцсан албан хаагчийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх | | | | тусгасан байх Жилийн эцэст: Чанартай бүхий талыг хамруулан гүйцэтгэсэн, төрийн албан хаагчид холбогдох мэдээллийг бүрэн тусгасан байх | холбоотой 19 мэдээллийг тус тус оруулж, цахим санд баяжилт хийсэн | |
| 4.1.4 | Албан хэрэг хөтлөлт, архивын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомжийн хэрэгжилт, албан бичгийн шийдвэрлэлт | Байгууллагын 2023 оны үйл ажиллагаатай холбоотой нийт 52 баримтыг албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу архивт шилжүүлсэн. 2024 оны баримт бичгийг бүрэн цахимжуулсан. | Эхний хагас жилд: Стандарт, зааврын хэрэгжилтийг хангасан байх Жилийн эцэст: Стандарт, зааврын хэрэгжилтийг хангасан байх | Тайлант хугацаанд Мал эмнэлгийн газрын даргын 31 тушаал гарч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллалаа. Бусад байгууллага, албан тушаалтнуудаас 103 албан бичиг ирснээс 34 албан бичгийг шийдвэрлэж, нийт 124 албан бичгийг шуудангаар болон Динамик, Абле дотоод шуудангаар холбогдох байгууллага, мэргэжилтэнд хүргүүлж, 6 өргөдөл хүлээн авч, 6 өргөдөл шийдвэрлэж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2022 оны 7 дугаар тогтоолын дагуу төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх ажлыг туршиж, байгууллагын 3 төрлийн хэвлэмэл хуудсыг аймгийн Архивын тасгаар хянуулан, баталгаажуулан 15 тушаал, 60 албан бичгийг монгол бичигт хөрвүүлсэн. | 100 |
| 4.1.5 | Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, дүрэм | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээ, мэдээллийн тоо | Аймаг, сумдын цахим хуудас, ОНХМА-тай хамтран 15 удаа мэдээллийг байршуулж, олон нийтэд түгээсэн ба мэдээллийн самбартаа 35 мэдээллийг тавьж | Эхний хагас жилд: 100 Жилийн эцэст: 150 | Аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл, мэдээллийн албанд цаг үеийн ажилтай холбоотой 2 мэдээ,мал эмнэлгийн газрын цахим хуудсанд халдварт шимэгчтэх өвчнөөс сэргийлэх тухай,мал эмнэлгийн хяналт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмыг таниулан сурталчилах, байгууллагын мэдээллийн хэрэгслийн ашиглалтыг нэмэгдүүлэх | | | хэрэглэгчийг мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулсан. Мал эмнэлгийн Газар facebook-д 287 удаа мэдээ, мэдээлэл нийтлэж 12618 иргэнд хүрч, нүүр хуудсыг 1922 дагагчаар нэмэгдсэн. | | шалгалт, халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын явц, Мал эмнэлгийн албаны гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой 72 мэдээллийг хуваалцаж, 28 удаа нийтлэн нийт 100 удаагийн давтамжтай мэдээ мэдээллийг иргэд, малчдад хүргэсэн байна.Цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл бэлтгэн, хуваалцаж байгаа нь цахим хуудсын хандалт 3481 болж 2024 оны мөн үеэс 60 хувиар нэмэгдэж, мэдээ мэдээлэл 12580 иргэд малчдад хүрсэн үзүүлэлттэй байна. | |
| 4.1.6 | Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах | Үйл ажиллагааны зардлаар | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна | Эхний хагас жилд: Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. Жилийн эцэст: Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Газрын даргын тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь тушаалын дагуу төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд Мал эмнэлгийн Ерөнхий газрын стратеги төлөвлөгөөтэй уялдуулах бөгөөд тус төлөвлөгөө нь хагас жилийн байдлаар батлагдаж ирээгүй болно. | 70 |
| **4.2.Санхүү, төсвийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4.2.1 | Үйл ажиллагааны болон мал эмнэлгийн арга хэмжээний батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулан гүйцэтгэлийг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн хувьд байгууллагын үйл ажиллагааг саадгүй явуулахад чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжсэн байна. | 2024 оны Үр дүнд суурилсан төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан МЭЕГазарт хүргүүлсэн бөгөөд төсвийн төслийн opengov.mn программд шивж байршуулан ажилласан. Санхүүгийн | Эхний хагас жилд: Төсвийн зарцуулалтын үр ашиг сайжирсан, санхүүгийн зөрчилгүй, өр авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагын санхүүгийн тайлан | 2025 оны байгууллагын төлөвлөгөөг батлуулан батлагдсан төсвийн хүрээнд хөтөлбөрийн зориулалтын дагуу зарцуулан 2025 оны 5 дугээр сарын 31-ны өдрийн байдлаар батлагдсан төсөв 426 518 400 төгрөг, гүйцэтгэл 2314 962 403 төгрөг буюу 73,85 хувийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөрчилгүй, үйл ажиллагааг тасралтгүй санхүүжүүлэн, тайлан мэдээг хугацаанд гарган, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. | мэдээг үнэн зөв гаргаж мэдээлэх Жилийн эцэст: Төсвийн зөрцуулалтын үр ашиг сайжирсан, санхүүгийн зөрчилгүй, өр авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагын санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж мэдээлэх | гүйцэтгэлтэй байна. Батлагдсан төсвийн санхүүжилтийг хугацаанд авч 1 хөтөлбөр 3 арга хэмжээний дагуу санхүүжилтийг зарцуулан ажилласан. Батлагдсан төсвийн зарцуулалт 73,85 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 4.2.2 | Төсвийн хүрээний мэдэгдэл, болон төсвийн төслийг боловсруулан дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлэх, гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд заасан хугацаанд иж бүрэн мэдээлсэн байх | Хуульд заасан хугацаанд төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж хүргүүлсэн. | Эхний хагас жилд: Зөрчилгүй, хуулийн хэрэгжилтийг хангасан байх Жилийн эцэст: Зөрчилгүй, хуулийн хэрэгжилтийг хангасан байх | Нийт төсвийн гүйцэтгэлийг задалбал Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд - 248 223 556 , Нийгмийн даатгалын шимтгэлд-31 500 926 ,байр ашиглалт зардал- 4 795 000 , хангамж, бараа материалын зардал - 4 520 530 , норматив зардал-0, эд хогшил, урсгал засварын зардал- 16 576 705 , албан томилолтын зардал -1 354 600 , бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардалд- 7 991 086 , бараа үйлчилгээний бусад зардал 0, урсгал шилжүүлэг - 0 төгрөгийг зарцуулсан байна. 2025 оны Үр дүнд суурилсан төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан МЭЕГазарт хүргүүлсэн бөгөөд төсвийн төслийн opengov.mn программд шивж байршуулан ажилласан. | 100 |
| 4.2.3 | Байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийг сайжруулах | Үйл ажиллагааны зардлаар | Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, тооллогын үр дүн | Үндсэн хөрөнгийн сар бүрийн тайланг хугацаанд нь гаргаж нягтлан бодогчоор хянуулан, байгууллагат шинээр худалдан авсан хөрөнгийг журмын дагуу орлогот авч | Эхний хагас жилд: Байгуулллагын эд хөрөнгийг зохистой ашиглах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, эд хөрөнгийн тооллого, тооцоо, | Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн "Тооллогын комисс томилох тухай" А/24 дугаар тушаалын дагуу тооллогыг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллагын үндсэн болон эргэлтийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үндсэн хөрөнгөд бүртгэсэн. | бүртгэлийг үнэн зөв чанартай хийх Жилийн эцэст: Байгуулллагын эд хөрөнгийг зохистой ашиглах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, эд хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлийг үнэн зөв чанартай хийх | хөрөнгүүдийг нүд үзэж, сери дугаарыг эд хөрөнгийн бүртгэлтэй тулгаж, албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийг картаар харьцуулан нэг бүрчлэн системтэй тулган тооллогыг явуулж, дүн мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулахаар бэлдэж байна. | |

ТАЙЛАН ҮНЭЛСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН
АХЛАГЧ Б.МӨНГӨНШҮР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН
ГИШҮҮН Н.БААСАНСҮРЭН

ГИШҮҮН В.ЭРХЗАЯА

ГИШҮҮН Б.БАЯРМАА

ГИШҮҮН Х.БАЛЖИННЯМ

ГИШҮҮН Н.БОЛОРМАА

ГИШҮҮН Ц.ГЭРЭЛЦЭЦЭГ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.МӨНГӨНШҮР

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА А.СУВДАА

ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Х.БАЛЖИННЯМ

ТАНИЛЦСАН:

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДОРЖ

1925040059